



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№41 /485/

2023.03.09

Цаг үе, үйл явдал

8 Марта

ЭРХЭМСЭГ ЦЭРГИЙН БҮСГҮЙЧҮҮДДЭЭ ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙН МЭНДИЙГ ХҮРГЭЭ!



ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ ЭМЭГТЭЙ АЖИЛТАН,
АЛБА ХААГЧДААА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



“ЦОЛ БҮХЭН САЙХАН” ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ



Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний түүхт 102 жилийн ойг угтах ажлын хүрээнд БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын бие бүрэлдэхүүний хамтын ажиллагааг бэхжүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэж, бие бялдраа чийрэгжүүлэх зорилгын дор зохион байгуулагддаг "Цол бүхэн сайхан" тэмцээн өнөөдөр эхэллээ.

Энэхүү тэмцээний нээлтийн үеэр БХЯ-ны СБТГ-ын Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн орон нутгийн хамгаалалт хариуцсан шинжээч дэд хурандаа Л.Жамбалсүрэнд Монгол Улсын Спортын мастер цол, БХЯ-ны БХЗГ-ын Материал, техникийн хангамжийг зохицуулах хэлтсийн дарга хурандаа Ж.Банзрагчид ЗХЖШ-ын даргын тушаалаар Цэрэгжлийн спортын

нэгдүгээр зэрэг олгосон нь тамирчин алба хаагчдын эгнээг өргөжүүлсэн сайхан үйл явдал болов. Энэ удаагийн тэмцээнд хурандаа болон дэд хурандаа нарын тус бүр хоёр баг, хошууч, ахмад, ахлах дэслэгч, дэслэгч, ахлагч нарын тус бүр нэг баг оролцож, буудлага, ширээний теннис, волейболын төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөх юм.

ЦЭРГИЙН СЭТГҮҮЛЧДЭД ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЖ ШАГНАЛ ГАРДУУЛЛАА



МЭНДЧИЛГЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦИЙН ХАМТ ОЛОНОД

Монгол Улсад Үндэсний сэтгүүл зүй үнэн хөгжсөний 110 жилийн ойн баярыг тохиолдуулан 100 жилийнхээ бүрэл түүхийг 2024 онд тэмдэглэн өнгөрдөг Монгол Улсын уран хэвлэлийн нэг “Соёмбо” сонин үе үеийн сэтгүүлч, уран бүтээлчүүд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нийт бие бүрэлдэхүүний нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээг дэвшүүцье!

Цэргээс оронч үзэх хүмүүжлийг үзгээрээ дийлдэмжүүлж, үйлдвэрээ мөнгөжүүлэхийг хэрэгтэй арга туршилтаар цэрэг дийчин алдаршуулаж, дарьчлаж тус нь болон өгөлдөг “Соёмбо” редакцийн хамт олонд бичиж шуурьх, түгээж нэвтрүүлэх их үйлсэд тань ондр амжилал хүсье!

Уг нь мөргөн, үзэг нь хэри, байх болтугай!

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН СЭТГҮҮЛЧДЭД ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЖ ШАГНАЛ ГАРДУУЛЛАА

2023.03.06

Монгол Улсад Үндэсний сэтгүүл зүй үүсэж хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин, Төрлийн цэргийн командлалуудын үйл ажиллагааг олон нийтэд сурвалжилж, сурталчлахад идэвх санаачилгатай ажиллаж буй “Соёмбо редакц”-ын зарим цэргийн сэтгүүлч, уран бүтээлчдэд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, БИЦУГ-ын удирдлага талархал илэрхийлж шагнаж урамшууллаа.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 13	☁️ -11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 29

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,531	3,534
EUR 🇪🇺	3,782	3,790
CNY 🇨🇳	509	512
RUB 🇷🇺	45.20	45.90
JPY 🇯🇵	26.10	26.40
KRW 🇰🇷	2.69	2.72

ЗУРХАЙ



2023.03.09 /ПҮРЭВ ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 17

**ХАВРЫН ТЭРГҮҮН ХӨХ БАР
САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ УЛААН
БАР ӨДӨР**

Үс засуулбал:
Өнгө зүс доройтно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.18-18.47
Барилдлага:
Арвидах
Шүтэн барилдлага:
Мунхрахуй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, сүм, суварга барих, хүүрийн газар эргэх, чуулан үймэхэд сайн. Нүд татваас эцэг эхэд аюул болох, баруун чих хангинавал эхнэртэй учрах, зүүн нь бол идээ ундаа олдох, нохой уливал гэнэт зочид ирэх болой. Энэ өдөр өндөр язгуурт хүний хэл ам болох, тагнай загатнавал их хүн ирэх, бие татвал хэрүүл тэмцэл болох, хөл татвал сайн.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 681,036,554

Эдгэрсэн

Нийт: 653,992,336

Нас барсан

Нийт: 6,807,819

Цахим шууданд

СОНСОГЧ ОХИДЫН ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж Монгол цэргийн нэгдсэн холбоо, түүний дэргэдэх Эмэгтэйчүүдийн клубийн удирдах зөвлөлийн гишүүд, Монгол ахлагч нарын Соёмбо холбоо хамтран ирээдүй хойч үеийн залгамж

халаа болсон төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын сургуулиудын сонсогч охидыг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын үед сонсогч охидод Монгол цэргийн нэгдсэн холбооны эрхэм зорилго, үйл ажиллагааны

талаар товч танилцуулж, Монголын анхны эмэгтэйчүүдийн байгууллагын үүсэл хөгжил, эмэгтэйчүүдийн нийгэмд оролцоогоо нэмэгдүүлэхийн ач холбогдол сэдвээр чөлөөт ярилцлага хийв.

МЦНХ

МӨРДЭСТЭЙ БҮСГҮЙЧҮҮД АВЬЯАС ЧАДВАРАА СОРИН ӨРСӨДЛӨӨ



Монгол Улсын Зэвсэгт хүчний 102 жил, "Монгол цэргийн өдөр", Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулагддаг цуврал тэмцээн "Мөрдөстэй бүсгүйчүүд" тэмцээнээр эхэллээ.

Тэмцээнд 5 байгууллагын 15 эмэгтэй цэргийн алба хаагчид оюун ухаан, авьяас чадвар, авхаалж самбаагаа сорин өрсөдсөнөөс тэргүүн байрт Монгол Улсын баатар Ж.Нэхийтийн нэрэмжит Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн ахлах дэслэгч Л.Сарантуяа ахлагчтай "Алтан гэрэгэ" багийн бүсгүйчүүд, дэд байрт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ахлах дэслэгч М.Биндэрьяа ахлагчтай "Сүлдэн заяа" багийн бүсгүйчүүд, гутгаар байрт Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын ахлах дэслэгч Э.Отгонбаяр ахлагчтай "Онцгой бүсгүйчүүд" багууд тус тус эзэлж амжилттай оролцлоо.

СЭЛЭНГЭ АЙМАГ ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ



Гэрэл зураг-нэг агшин



Эр цэргийн амжилт
Энгэрт гялалзах мөч

ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨРТ ЗОРИУЛСАН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 30 жилийн ой, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулсан тэмцээнүүдэд амжилттай оролцсон шилдгүүдэд шагналыг гардууллаа.

Арга хэмжээний хүрээнд 102 жилийн түүхт ҮБХИС-д 47 жил ажилласан ахмад ажилтан Ц.Шүрэнцэцэг тэргүүтэй 170 гаруй эмэгтэй ажилтан, албан хаагчдад мөр зэрэгцэн алба хааж буй эрчүүд нь хүндэтгэл үзүүлсний зэрэгцээ "Гар бөмбөг, "Аяг тaa" хөгжөөнт тэмцээн болон сонсогч, оюутан, сурагч, хугацаат цэргийн албан

хаагчдын дунд зохион байгуулсан "Ээждээ захидал бичээрэй" захидлын уралдааны шилдгүүдэд шагналыг гардууллаа.

Захидлын уралдаанд тусгай байрт Аюулгүй байдлын дээд сургуулийн III дамжааны оюутан Б.Пүрэвдолгор, гутгаар байрт Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сонсогч Б.Бат-Амгалан, дэд байрт харуул үйлчилгээний ротын байлдагч С.Булганхангай, тэргүүн байрт Аюулгүй байдлын дээд сургуулийн II дамжааны оюутан П.Ариунчимгийн "Ид шидэт сахиусан тэнгэр" захидал тус тус шалгарч бусад нөхдөө манлайллаа.

ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН АР ГЭРТ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



"Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 015 дугаар анги Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай "UNMISS" энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй офицер, ахлагч нарынхаа гэр бүлийн төлөөллийг хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

Уулзалтын хүрээнд ангийн удирдлагууд цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөлөлд анги байгууллагынхаа талаар товч танилцуулсны зэрэгцээ "Дайчин алдар"-ын танхимаар зочлуулж цэргийн алба хаагчдын бэлтгэсэн урлагийн тоглолтыг сонирхууллаа.

Энэ үеэр БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж байгаа ахлах ахлагч С.Баттулга, ахлагч Н.Дорждэрэм

нар онлайнар холбогдож үүргээ нэр төртэй сайн гүйцэтгэж байгаагаа ангийн захирагчдаа илтгэсний зэрэгцээ сэтгэлийн их дэм өгч ар гэрийнхнийг нь хүлээн авч уулзаж байгаад чин сэтгэлээсээ талархсанаа илэрхийлж үүргээ сайн гүйцэтгээд эх орондоо эрүүл саруул очихдоо итгэл дүүрэн байгаагаа хэлсэн юм.

Уулзалтын төгсгөлд ангийн захирагчийн зүгээс цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөлөлд хандан чин сэтгэлийн талархал илэрхийлж дэлхийн энх тайвны төлөө хүчин зүтгэж буй энэ цагийн эгэл баатруудынхаа ар талыг найдвартай дааж үүргээ тайван гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангаж явдаг бүсгүйчүүдээрээ бахархаж байгаагаа илэрхийлсэн юм.

Дэслэгч Б.ЗОЛЗАЯА